

ХАНДИВЛАГЧДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

**Б.НАРАНЧИМЭГ, Эдийн засагч-Хүн ам зүйч, МУИС-ийн Хүн Амын Сургалт
Судалгааны Төвийн эрдэм шинжилгээний ажилтан**

“Хандивлагчдын хөрөнгө оруулалт” гэсэн ойлголт нь зах зээлийн системд шилжин орсонтой холбогдон гарч ирсэн шинэ ойлголт биш юм.

Ардын хувьсгал ялснаар монгол улсыг тууштай хөгжүүлэх хөгжлийн гараа эхэлсэн гэж хэлж болно. Тухайн үеийн хөгжил, цэцэглэлт, бүтээн босголт нь орос ах гэгддэг хуучин ЗХУ болон бусад социалист системийн улс орнуудын хөрөнгө оруулалт дээр түшиглэж байсан нь монголчуудыг бэлэнчлэх сэтгэлгээтэй болон төлөвшихөд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг.

Хэдийгээр өмнөх тогтолцооны үед нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын салбарт бахархмаар амжилт олсон боловч монгол хүний хөгжилд чухал байр суурь эзэлдэг үйлдвэрлэл, орлого бий болгох чадавхийг бэхжүүлж чадаагүй нь харуусал төрүүлмээр.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцтай холбогdon нийгэм, эдийн засгийн хямралд орж, улмаар ард түмний амьжиргааны түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан юм.

Хөрөнгө мөнгөний хомсдол, санхүүгийн хямралаас үүдэн ихэнхи үйлдвэрүүд зогсож, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дампуурлын хар сүүдэр нөмөрсөн нь ажилгүйдэл, ядуурал нийгмийн томоохон асуудал болон гарч ирэх үндэс суурийг тавив. Түүнчлэн өмнөх тогтолцооны үед амжилт олоод байсан нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбарт төрөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ багасаж, үйлчилгээний чанарыг бууруулахад нөлөөлжээ. Энэ бүхэнтэй холбоотойгоор хүний чанар, хөгжлийн асуудал доройтож өмнө нь хүрсэн түвшнээсээ ухрахад хүрсэн билээ.

Ийнхүү хөрөнгө, капитал ядуутай хөгжиж байсан манай улсын хувьд гадаадын капиталыг өөртөө татах асуудал чухлаар тавигдаж, төр засгийн газраас хандивлагчдын хөрөнгө оруулалтыг татах бодлого авч явуулсан нь амжилттай хэрэгжиж байв. 1991 онд гадаадын зээл, буцалтгүй тусламжийн нийт хэмжээ 95.7 сая ам. доллар байсан бол 1997 онд хамгийн өндөр буюу 267.2 сая ам. доллар, 2000 онд 160.5 сая ам. доллар байлаа⁵.

Манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд маш олзуурхууштай зүйл болж байсан хандивлагчдын хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламжууд нь эхэн үедээ шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад зориулагдаж байсан бол яваандаа тодорхой салбар руу чиглэсэн, зорилготой болж эхэлсэн юм. Тухайлбал, гадаадын нийт хөрөнгө оруулалтын 29.4 хувь нь аж үйлдвэр, 16.9 хувь нь уул уурхай, 15.1 хувь нь хөдөө аж ахуйн материал боловсруулалт, 13.6 хувь нь хөнгөн үйлдвэр, үлдсэн нь бусад салбарт ногдож байлаа⁶.

⁵ СЭЗЯ, Эдийн засгийн хяналт, шинжилгээ үнэлгээний газрын мэдээ.

⁶ МУ-ын Засгийн газрын Гадаад хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, 1998 оны мэдээ

Шилжилтийн үр нөлөөгөөр ядуурлын түвшин нэмэгдсэн нь хот, хөдөөгийн ялгааг улам нэмэгдүүлж, хөдөөнийхөн хөгжлөөс хоцроход хүргэж байна гэхэд хилсдэхгүй болов уу. Хөдөөгийн ард түмэн зах зээлээс алслагдсаны дээр дэд бүтэц сайн хөгжөөгүй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ажлын байр хомсдолтой, мэдээллээс түргэн шуурхай хүртэх боломжгүй байдаг нь амьжиргааны түвшнийг доройтуулахад нөлөөлж байна. Түүнчлэн нийгэм, эдийн засаг, байгаль, цаг уурын таагүй үзэгдлүүд нь хөдөөгийнхний амьжиргааны гол эх үүсвэр болох бэлчээрийн мал аж ахуйг доройтуулж байгаа юм. Харин хотын хүн амын хувьд хөдөөнийхөнтэй харьцуулахад хөгжин дэвжих бололцоо, нөхцөл нь бүрэлдэн тогтсон.

Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдлыг хандивлагчдын хөрөнгө оруулалттай шууд холбож тайлбарлахад бэрхшээлтэй боловч тэдгээрийн үзүүлж буй туслалцаа хүний хөгжилд тодорхой хэмжээний зөрэг нөлөө үзүүлж байгааг дурьдах нь зүйтэй. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай янз бүрийн түвшний сургуулиуд, эмнэлгийн зориулалттай өндөр оношлогооны аппарат, шинэ техник, технологи, хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүд (үүнд: ЯБҮХ, НҮЭМ-ийн хөтөлбөр гэх мэт), барилга, тээвэр, холбоо, мэдээллийн салбар дахь хөрөнгө оруулалт гэх мэт.

Хэдий тийм боловч хөгжлийн энэхүү тусламж нь хот, хөдөөд ялгаатай тусч байна. 1991 оноос хойш манай улсад үзүүлсэн хандивлагчдын нийт хөрөнгийн /1897.1 сая ам. доллар - зээл, буцалтгүй тусламж/ дөнгөж 8 хувь нь хөдөө аж ахуйд зарцуулагдсан ажээ⁷. Харин хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшин нь хотын хүн амын амьжиргааны түвшинтэй харьцуулах ч юм биш. Хандивлагчдын хөрөнгө оруулалт болон хүн амын амьжиргааны түвшний хот, хөдөө дэх ялгаатай байдал ийм хол зөрүүтэй байгаа нь хүний хөгжлийн ялгаатай байдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа юм шиг.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хөдөө аж ахуйд зориулан явуулсан тусламж, төсөл, хөтөлбөрүүдийн тоо 20 давсан боловч тэдгээрийн үр дүн хүний хөгжилд ямар нөлөө үзүүлсэн юм бол? Тэр бүх хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан юм биш биз? Магадгүй зарим нэг нь үнэхээр хөрөнгө зарсан ажил болоод өнгөрсөн ч байж болох юм. Тухайн ажлыг хийх үндэслэл сайн биш байсан ч юм уу, эсвэл цаг үеэ олоогүй байсан зэрэг нь нөлөөлсөн байж болох юм. Гэхдээ Говийн эмэгтэйчүүд, Ногоон хувьсгал, Цагаан сүү, Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр, Өрхийн аж ахуйд зөвлөгөө өгөх төсөл зэрэг хэд хэдэн төсөл, хөтөлбөр нь өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд, цаашилбал боловсролын түвшинг дээшлүүлэх, хөгжлийг дэмжихэд зэрэг нөлөөтэй байсныг дурдах нь зүйтэй.

Эцэст нь хэлэхэд хандивлагчдын хөрөнгө оруулалт нь манай улсын хувьд хэрээс хэтрээд байгаа болов уу. Орж ирж буй төсөл, хөтөлбөр, хандивлагчдын хөрөнгө оруулалт бүрийг олзуурхаад, алгаа тосож аваад байх юм бол манай улсын эдийн засгийн байдал, төлбөрийн тэнцэл алдагдаж гадаад өр, зээлийн хэмжээ нэмэгдсээр л байх болно. Улмаар үндэсний үйлдвэрлэл, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буурахад ч нөлөөлж болох юм.

НҮБ-ын олон улсын шинжээчдийн хийсэн судалгаагаар манай улсын нэг хүнд ногдох орлого 1989 оны түвшнээс 80 хувиар доогуур гарсан байна.

⁷ СЭЗЯ, Мэдээлэл хяналт шинжилгээ үнэлгээний газар, 2000 оны мэдээ

Түүнчлэн хандивлагчдын зээл тусlamжаас хараат байдлаараа дэлхийд 5-р байр эзлэх болжээ⁸. Энэ бүхнээс харахад хандивлагчдын зээл, буцалтгүй тусlamжинд тулгуурлан хөгжиж болдоггүй нь харагдаж байна.

Хэдийгээр манай улс хөрөнгө, капитал ядуутай хөгжиж байгаа ч гэсэн бусад хөгжингүй орнуудын туршлагаас суралцан гадны зээл, тусlamжийг зөв механизмаар авч ашиглавал улс орноо хөгжүүлэх бүрэн бололцоотой.

⁴ Шинжлэх Ухааны Академи, Үндэсний Хөгжлийн Хүрээлэн, “Монгол Улсын Үндэсний Хөгжлийн Хөтөлбөр боловсруулах арга зүй, аргачлал”, 2002 он